



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлын дэргэдэх удирдлагын
зөвлөлийн гишүүд, зөвлөлийн ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн Гүйцэтгэх захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэх, оновчтой шийдвэр гаргахад зөвлөх, ажлын үр дүн, үр нөлөө, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий удирдлагын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Ч.Раднаабазар (Гүйцэтгэх захирал)

Гишүүд:

Д.Ганзориг (Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ, хариуцсан менежер)

Н.Пүрэвсүрэн (Ахлах мэргэжилтэн)

Г.Ганцэцэг (Ахлах нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга:

Д.Номин-Эрдэнэ (Захиргааны мэргэжилтэн)

2.Гүйцэтгэх захирлын дэргэдэх удирдлагын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/48 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР